



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,  
Факс: (976-11) 45 86 99, И-мэйл: info@nccd.gov.mn,  
Вэбсайт: www.nccd.gov.mn

2019.09.17 № 11/66  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

Дархлаажуулалтыг зохион  
байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”, 2000 оны “Дархлаажуулалтын тухай” хууль, 2009 оны 185 тоот “Дархлаажуулалтын үндэсний товлалыг шинэчлэн батлах тухай” тогтоолд заасны дагуу 7, 15 настайд сахуу, татрангийн эсрэг вакцины дархлал сэргээх тунгаар дархлаажуулах үйл ажиллагааг 2019 оны 9 дүгээр сарын 20-30-ны өдрүүдэд ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид суралцаж буй зорилтот насанд хийх тул бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулна уу.

Үүнд:

1. Харьяа ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн хамрагдвал зохих 7, 15 насны хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргах (төрсөн он, анги бүлгээр),
2. Дархлаажуулах шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийн тооцоог гаргаж захиалах, хүлээн авч, нэгжүүдэд түгээх,
3. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, аргазүйч, эмч, багш нарт дархлаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг өгч, хамтран ажиллах,
4. Дархлаажуулалт эхлэхээс өмнө сургуулийн удирдлага, эмч, багш нар эцэг эх асран хамгаалагч нарт вакцинжуулалтын талаар мэдээлэл өгөх,
5. Дархлаажуулалтын түр цэгийг ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид байгуулах,
6. Сахуу, татрангийн эсрэг вакциныг зохион байгуулах бичил төлөвлөгөөг гаргах (сургууль, өрх, сум, аймаг, дүүрэг, нийслэл). Аюулгүй дархлаажуулалтыг баримтлан дархлаажуулалтыг зохион байгуулж, тогтмол хяналтыг тавих,
7. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтыг хийж, эцэг, эх, багш, сурагчдад мэдээллийг зөвлөмжөөр өгөх,
8. Хамралтын тайлан мэдээг дараа сарын товлалын дархлаажуулалтын сарын мэдээний хамт холбогдох журмын дагуу цаг хугацаанд нь мэдээлэх.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.НЯМХҮҮ

My document/2019 alban toot



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,  
Факс: (976-11) 45 86 99, И-мэйл: info@nccd.gov.mn,  
Вэбсайт: www.nccd.gov.mn

2019.09.17. № 11/67  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН  
БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

Хамтран ажиллах тухай

Монгол улсын “Дархлаажуулалтын тухай” хууль, Засгийн газрын 2009 оны 185 тоот “Дархлаажуулалтын үндэсний товлалыг шинэчлэн батлах тухай” тогтоолд заасны дагуу сахуу, татрангийн эсрэг вакцинаар улсын хэмжээнд 7, 15 настай хүүхдүүдийг вакцинжуулах ажлыг жилд нэг удаа зохион байгуулдаг бөгөөд 2019 оны 9 дүгээр сарын 20-30-ны өдрүүдэд дархлаажуулна.

Уг ажлын хүрээнд аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежуудад дархлаажуулалтын цэгийг нээж сургууль дээр суурилан вакцинжуулах ажлыг зохион байгуулдаг.

Иймд, дараахь арга хэмжээг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллана уу. Үүнд:

1. Сургууль бүрээр вакцин хамрагдах 7, 15 настай хүүхдийн судалгааг анги бүлэгээр нарийвчлан гаргах;
2. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежуудад дархлаажуулалтын явуулын цэг нээж хамрагдах насны хүүхдийг дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах, хүүхдүүд болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад вакцинжуулалтын талаар мэдээлэл өгөх;

Дээрх асуудлаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны 451158, 451798 дугаар утсанд холбогдон нэмэлт мэдээлэл авч болно.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.НЯМХҮҮ

My document/2019 alban toot